

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ¹ 15 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 15.00 цагт эхэлж, 16.10 цаг хүртэл Засгийн газрын 11 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Гадаад хэргийн яамны зарим газрын дарга нарын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан дүнгийн тухай	Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирлын албан тушаалуудад Б.Баярсайхан, Г.Жаргалсайхан нарыг томилуулахаар тус тус дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатарт санал болгосон тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол.
2	“Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын тухай	“Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын төслийг Монгол Улсын Засгийн газарт өргөн барихаар шийдэв.
3	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан О.Байгалмаагийн гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан О.Байгалмаагийн гаргасан гомдлыг харьяаллын дагуу Монгол Улсын Засгийн газарт шилжүүлэхээр шийдэв.
4	Нийслэлийн Баянгол дүүргийн Цагдаагийн хэлтсийн ажилтан байсан Б.Баярсайхан, мөн Замын цагдаагийн газрын ажилтан байсан Б.Жаргал нарын гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	Төрийн албаны зөвлөлийн тогтоол
5	Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байсан Сандагийн Үржинг хүсэлтийн нь дагуу төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	С.Үржинг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ